



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



JAPAN INTERNATIONAL
COOPERATION AGENCY

**Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих төсөл
(DPUB)**

**5-р сарын 23-ны өдрийн ХБИ-ийн цуврал сургалтын талаарх мэдээлэл NTV сувгийн мэдээний нэвтрүүлгээр цацагдлаа.
(2018.05.30)**

Олон улсад ХБИ-ийн талаар баримталж буй бодлого сайтай улс орнуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдөө төр засаг, нийгэмд хэрэгцээ, шаардлага илэрхийлэн, ХБИ-ийн эрхийг баталгаажуулахын төлөө тэмцсээр ирсэн байдаг. Тус цуврал сургалтаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ХБИ-ийн нөхцөл байдлын талаар зөв ойлголт өгөх, тэдний бодлого боловсруулах түвшний оролцоог дэмжих зорилготой. Энэ удаагийн хичээлийн сэдэв нь Хөгжлийн бэрхшээлийн статистик мэдээлэл байлаа. Сургалтанд идэвхтэй оролцсон төрийн албан хаагчид, ХБИ-дэд талархал илэрхийлье. Холбогдох мэдээлэлтэй доорх линкээр орж танилцаарай.

<https://www.facebook.com/ntvmn/videos/1877233205641179/> (27-р минутаас үзнэ үү.)



Сургалтын үеэр

Меконг голын усанд сэлэлтийн тэмцээн



Төслийн ахлах зөвлөх Чива Хисао

Ажлаас гадна Камбожид болсон хамгийн дурсамжтай зүйл гэвэл Меконг голын усанд сэлэлтийн тэмцээнд оролцож, 2-р байрт орсон явдал юм. Тухайн үед усанд сэлэлтийн багшаар ажиллаж байсан ЖАЙКА-ийн сайн дурын гишүүн надад тус тэмцээнд оролцох саналыг тавьсан. Тэмцээний дүрэм маш амархан байсан бөгөөд Меконг голын нэг эргээс нөгөө эрэг хүртэл хамгийн хурдан сэлж гарсан хүн ялагч болох байлаа. Үнэндээ бол нийслэл Пном Пен хотыг дайран урсдаг гол нь Тонле Сап бөгөөд Меконг голд цутгадаг. Гэхдээ л голын өргөн 400 метр, дээрээс нь голын урсацыг тооцоолж үзвэл нийт 600 метрт сэлэх болсон. Уг тэмцээнд нийт 100 гаруй хүн оролцсон бөгөөд жижиг завиар голын нөгөө эрэгт хүргүүлсэн юм. Оролцогчдын ихэнх нь Камбож хүмүүс байсан ба Япон хүн ойролцоогоор 5 байв. Голын эргийг цементлээгүй байсан учраас өвсөн дундуур явж голын усанд ороод эхлэх дохио хүлээлээ. Гэтэл өвсний цаанаас дохио өгөх хүн ч харагдахгүй, хэзээ дохио өгөхийг нь мэдэхгүй хүлээж байтал оролцогчид нэгэн зэрэг сэлж эхэлсэн учраас би ч гэсэн яаран ус руу орлоо. Голын ус нэлээд булингартай байсан учраас өөрийнхөө гарыг ч харах боломжгүй байсан. Сэлэх явцдаа зүг чигээ харахын тулд уснаас толгойгоо гаргаад барианы газраа шалгасан боловч, миний эргэн тойронд сэлж байгаа хүн харагдахгүй байлаа. Хэдэд сэлж байгаагаа ч мэдэлгүй, ямар ч л байсан барианы газар хүртэл сэлэхээс өөр арга байгаагүй. Нүдний өмнө барианы газар харагдаад одоо жоохон л сэлвэл орлоо доо гэж бодтол доошоо голын усанд урсаад явчихав. Ямар ч арга байхгүй учраас барианаас жоохон зайтай голын эрэг дээр гараад бариа руу алхаад очлоо. Гэтэл зохион байгуулагч ажилтан “Баяр хүргэе!” гэсээр угтсан бөгөөд би 2-р байранд орсон байлаа. Ингээд ЖАЙКА-ийн Төлөөлөгчийн газрын даргаас медаль, шагналын мөнгө авч, ТВ-ийн ярилцлага хүртэл өгсөн. Тэр нэвтрүүлгийг үзсэн хамт ажилладаг Камбож хүмүүс, найзууд маань маргааш өдөр нь баяр хүргэж, тэмдэглэсэн нь сайхан дурсамж болж үлджээ. Энэ тэмцээнд оролцоноор зөвхөн ажил бус, өөр бусад арга хэмжээнд оролцоноор хүмүүстэй илүү дотносож, ажил амьдралаа хөгжилтэй, идэвхтэй өнгөрүүлж болохыг мэдэж авсан. (Үргэлжлэл бий...)

JICA DPUB фэйсбүүк хуудсанд **LIKE** дарж нэгдээрэй!!

Төслийн фэйсбүүк хуудсанд LIKE дарсан нийт хүний тоо **2428** болж, маш олон хүнд төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүрэх боллоо. Цаашид ч гэсэн олон сонирхолтой мэдээллүүдийг та бүхэнд хүргэхийн тулд хичээн ажиллах болно.





Төслийн ахлах зөвлөх Чиба барилгын салбарын мэргэжлийн сэтгүүл болох “Барилга.МН” –д ярилцлага өгч, төслийн үйл ажиллагааны талаар танилцууллаа. ХБИ-ийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд барилгын салбарынхны ойлголт, хамтын ажиллагаа үнэхээр чухал. Тиймээс уг ярилцлагыг барилгын салбарт ажиллаж буй олон хүмүүс уншаасай гэж хүсэж байна.

Хүн бүрт хүртээмжтэй орчныг бүрдүүлэхэд барилгынхан гол үүргийг гүйцэтгэдэг (2018.06.05)

ХНХЯ, ЖАЙКА-тай хамтран 2016 оноос төслийг албан ёсоор хэрэгжүүлж эхэлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд оролцоход барилга байгууламжийн хүртээмжтэй байдал, дэд бүтцийн хөгжил ихээхэн чухал үүрэг гүйцэтгэдэг. Тийм учраас төслийнхөө нэг чиглэл болгож дэд бүтэц, орчны хүртээмжийг сайжруулахад анхаарч байгаа. Үйл ажиллагааныхаа хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, төрийн байгууллагынхантай хамтарч дэд бүтцийн үнэлгээний ажлыг зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд бодит байдал дээр тэдгээрийг хэрэглэж чадаж байна уу, үгүй юу гэдгийг шалгасан. Барилгын салбарынхан бусдаас түрүүлж хандлага, ойлголтоо өөрчилж чадвал маш их үр дүнд хүрэх юм. Тиймээс төслийн зүгээс зохион байгуулж буй DET болон бусад сургалтуудад барилгын салбарынхан нэн түрүүнд хамрагдаасай гэж хүсэж байна. ХБИ-д ээлтэй нийгэм гэдэг нь бүх хүнд ээлтэй нийгмийг хэлж буй учраас барилгын салбарынхан маань бидэнтэй хамтарч ажиллавал баяртай байх болно оо.

5 сарын 17-ны "ХБИ-ийн тоо баримтын тухай нээлттэй семинар" NTV телевизийн мэдээний нэвтрүүлгээр цацагдлаа. (2018.05.30)

NTV-ийн мэдээгээр Үндэсний Статистикийн хорооны ХАНСГ-ын дарга А.Амарбал болон төслийн ахлах зөвлөх Чиба нарын ярилцлага, Монгол Улсын Засгийн Газраас хөгжлийн бэрхшээлийн статистик мэдээллийг олон улсад харьцуулах боломжтой, зөв тодорхой гаргахын тулд ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаа үйл ажиллагааны талаар танилцууллаа. Одоогийн байдлаар Монгол улсад 103 мянга орчим ХБИ байгаа гэсэн мэдээлэл байгаа бөгөөд олон улсад ашиглаж буй хөгжлийн бэрхшээлийн статистик аргачлалыг ашиглавал энэ тоо өөрчлөгдөх магадлалтай.

Мэдээллийг доорх линкээр орж үзнэ ҮҮ.
<https://www.facebook.com/ntvmn/videos/1870899972941169/>
 (27-р минутаас)



А.Амарбал дарга

6-р сарын 12-ны өдөр хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төслийн ажлын хэсэг анхдугаар хурлаа зохион байгууллаа. (2018.06.13)

ТББ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, төрийн албан хаагчид, төслийн хамт олон гээд нийт 27 хүний бүрэлдэхүүнтэй хурал зохион байгуулагдлаа. ХНХЯ-ны Хүн амын хөгжлийн газрын дарга С.Тунгалагтамир хурлыг удирдан явуулсан бөгөөд төслийн ахлах зөвлөх Чиба Хисао хурлыг нээн үг хэлцгээв. Түүний дараа хуулийн зөвлөхийн зүгээс цаашид хийгдэх хуулийн шинэчлэлтэй холбоотой үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулсан ба асуулт хариултын үеэр хуралд оролцогчидтой хэлэлцүүлэг өрнүүллээ. Тус хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулахад ТББ, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон төрийн байгууллагуудын төлөөллүүдийн хэлэлцүүлэг тун чухал ач холбогдолтой.



Хуулийн зөвлөх Д.Сүнжид

DPUB連絡先

Office: Government Building – 2, United Nation’s Street – 5, Ministry of Labor and Social Protection Ulaanbaatar – 15160, Mongolia

Facebook: <https://www.facebook.com/jicadpub>

Website: <https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html>

E-mail: dpub.jica@gmail.com